



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар A/159

Булган


Ажлын хэсэг байгуулж,
удирдамж батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Засгийн газрын 2017 оны 01 дугаар албан даалгавар, 2018 оны 258 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тогтоол, албан даалгаврын хэрэгжилтийг шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан удирдамжийн дагуу шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, дүнг 2019 оны 04 дүгээр сарын 20-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг /О.Наранжаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190189

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН “ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА,
ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ” 2017 ОНЫ 01 ТООТ АЛБАН
ДААЛГАВАР, 258 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ
ХИЙХ УДИРДАМЖ

Зорилго:

Монгол улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 01 тоот албан даалгавар, 258 дугаар тогтоолын хэрэгжилт, төрийн албаны сахилга хариуцлагын түвшинд үнэлэлт дүгнэлт өгөх, ёс зүйн зөрчлийг илрүүлэх, таслан зогсооход оршино.

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Ахлагч:

- О.Наранжаргал – Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн дарга

Гишүүд:

- Б.Одхүү – Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн
- З.Гомбо – Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

Хугацаа: 2019 оны 03 дүгээр сарын 25-аас 04 дүгээр сарын 15-ны хооронд явагдана.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогын талаарх мэдээлэл цуглуулах, таслан зогсоох
- Төрийн албан хаагч ажлын цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, мөрийтэй тоглох явдлыг илрүүлэх, таслан зогсоох
- Төрийн албан хаагч ажлын бус цагаар ажлын байранд болон бусад газар согтууруулах ундаа хэрэглэх, мөрийтэй тоглох явдлыг илрүүлэх, таслан зогсоох
- Төрийн байгууллагын аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалтын ажилтны сонор сэрэмжийг шалгах.

Шалгалтын дүнг нэгтгэх:

Хяналт шалгалтын дүнг 2019 оны 04 дүгээр сарын 20-ны дотор дүнг нэгтгэн, аймгийн Засаг даргад танилцуулна.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг баримтжуулж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.